

**“ГОЛОМТ БАНК” ХХК, “ЖАСТ АГРО” ХХК БОЛОН “БИДИСЕК” ХК-НЫ
ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ**

УЛААНБААТАР

№

2011 он 05 сар 17 өдөр

Нэг талаас “Голомт банк” /Бондын худалдан авагч гэх/ нөгөө талаас “Жаст Агро” ХХК /цаашид бонд гаргагч гэх/ болон “БиДиСек” ХК /зуучлагч гэх/ нар дор дурьдсан асуудлаар харилцан тохиролцож, энэхүү санамж бичгийг үйлдэв.


1. Бонд гаргагч нь дараах нөхцөлтэй бондыг Зуучлагчаар дамжуулан хөрөнгийн зах зээлд гарган арилжаалахаар ажиллаж байгаа болно.
 - a. Хугацаа: 1 жил
 - b. Бондын нэрлэсэн үнэ: 10 000
 - c. Хүү төлөх нөхцөл: 90 хоног
 - d. Хүү: 16,2%
 - e. Хэсэгчлэн гаргах хэмжээ: 10 тэрбум
 - f. Давтамж: 3 удаа
 - g. Нийт дүн: 30 тэрбум
 - h. Санхүүжилтын зориулалт: Мах бэлтгэлийн ажлыг санхүүжүүлэх
 - i. Бондын баталгаа: Үл хөдлөх хөрөнгө болон борлуулалтын гэрээ
2. Бонд гаргагч нь дээрх бондыг гаргаж буйтай холбогдуулан Бонд худалдан авагчдын өмнө дор дурьдсан үүргүүдийг хүлээнэ.
 - a. Бонд гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлнэ,
 - b. Бонд гаргагч нь Бонд худалдан борлуулснаас орсон орлогыг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна,
 - c. Бонд гаргагч нь бондын хүүгийн болон үндсэн төлбөрийг графикын дагуу цаг хугацаанд нь төлнө,
 - d. Бонд гаргагч нь Бондын үүргийн гүйцэтгэлийг хангахуйц үнийн дүн бүхий, өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө болон борлуулалтын гэрээгээр бондын баталгаа гаргана
 - e. Бонд гаргагч нь үйл ажиллагааны болон бусад хүчин зүйлээс хамаарч Бондын хүүгийн болон үндсэн төлбөр төлөлтөд гарах эрсдлийг өөрийн хөрөнгөөр хариуцана.
3. Бонд худалдан авагч нь 1-д заасан нөхцөлтэй бонд гаргах зөвшөөрөл эрх бүхий байгууллагаас (Санхүүгийн Зохицуулах Хороо) гарсны дараа үнэт цаасны бүрдүүлбэртэй танилцсаны үндсэн дээр тус бондоос 10 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний бондыг худалдан авах сонирхлоо үүгээр илэрхийлж байна.
4. Зуучлагч нь доор дурьдсан үүрэгтэй ажиллана.



- a. Зуучлагч нь Бондын танилцуулгыг хараат бусаар хийж гүйцэтгэн Бонд худалдан авагчид танилцуулна.
- b. Бонд худалдан авагч нь өөрийн үнэт цаасны дансанд Бонд худалдан авч байршуулахад Зуучлагч нь холбогдох брокерын үйлчилгээг үзүүлнэ.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

"ГОЛОМТ БАНК" ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ



F. ГАНХУЯГ

"ЖАСТ АГРО" ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Т.СОДНОМДАРЖАА

"БИДИСЕК" ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ


Б.ЛХАГВАДОРЖ







А.62